



**ДУНГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2010 оны 10 сарын 01 өдөр

Дугаар 49

Мандалговь

Автомашинд үнэлгээ тогтоож,  
худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсгийн 77.2.3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар бүлгийн 6.4 дахь хэсгийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

Нэг: Сайхан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2007 онд ашиглалтанд орсон 14,652,000 (арван дөрвөн сая зургаан тавин хоёр мянга) төгрөгийн балансын үнэтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 37-84 ДУА улсын дугаартай УАЗ-31512 маркын автомашины худалдах доод үнийг 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгөөр тогтоон дуудлага худалдаанд оруулахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар (С.Ууганбаяр)-г үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Сайхан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал О.Түмэнбаатарт даалгасугай.

Дөрөв: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА *О. Сүхбаатар* С.СҮХБААТАР

